
ХИМИЙН ОЛИМПИАД · ТҮВШИН ТОГТООХ

25 бодлого

Чи одоо хаана байна?

Олон улсын болон бүс нутгийн олимпиадын бодлогуудаас сонгосон, өөрийн түвшнээ тодорхойлоход зориулсан эмхэтгэл.



ЭМХЭТГЭСЭН

Мөнх-Энэрэл Батжаргал

Органик · Органик бус · Физик хими


2026

Химийн бодлогын эмхэтгэл

Түвшин тогтоох 25 бодлого

Бодлого 1. 1,2,3-Трифенилпропан-1,3-диолын стереоизомерууд (Tier −5)

Эх сурвалж: ОУХО-ийн бэлтгэл бодлого, 2020, Турк (Бодлого 8)



1.1. 1,2,3-трифенилпропан-1,3-диолын боломжит бүх стереоизомерыг **зур**.

1.2. Ахираль бүх нэгдлийг **жагсааж бич**.

1.3. Хираль бүх нэгдлийг **жагсааж бич**.


1.4. Дараах шинж чанар, аргуудын алийг нь ашиглан **1.3**-р асуултын хираль нэгдлүүдийг хооронд нь ялгаж болох вэ? Зөв хариулт бүрийг **сонго**.

- ☐ буцлах температур
- ☐ хэт ягаан туяаны (UV) спектроскопи
- ☐ хугарлын илтгэгч
- ☐ хайлах температур
- ☐ оптик эргүүлэлт
- ☐ диполь момент
- ☐ ахираль орчин дахь ЦСР спектроскопи
- ☐ нил улаан туяаны (IR) спектроскопи


Бодлого 2. Витамин B5 (пантотений хүчил) (Tier −5)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 2-р бодлого) · нийт 6 оноо

Пантотений хүчил нь усанд уусдаг В витаминуудын нэг юм. Пантотены хүчил нь пантойны хүчил ба β-аланины нийлбэр бөгөөд бараг бүх төрлийн хүнсэнд бага хэмжээгээр агуулагдаж байдаг. Уг витаминыг хүн ба амьтан хоол тэжээлээрээ дамжуулан заавал авах шаардлагатай ба биед орсноор коэнзим А нийлэгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн болдог. Коэнзим А нь ууураг, нүүрсус, өөх тосны задрал ба нийлэгжилтэд оролцдог гол бодисуудын нэг юм.



Витамин B5-ыг үйлдвэрт дараах схемийн дагуу нийлэгжүүлэн гарган авдаг.



Даалгавар 1. А бодис нь 66,63% C, 11,18% H ба хүчилтөрөгч агуулсан задгай хэлхээтэй альдегид бөгөөд ^{1}H-ЦСР спектрт 3 пик өгдөг. **А** бодисоос 200 г авч, 40%-ын формалины 224 г уусмал дээр нэмээд 160 г калийн карбонатыг бага багаар нэмж тасалгааны температурт урвалыг явуулан 72 г жинтэй $C_5H_{10}O_2$ томьёотой **В** бодисыг гарган авчээ. **А** бодисын эмпирик томьёог олж, **А** болон **В** бодисуудын бүтцийг зурна уу. **(1,5 оноо)**

А бодисын эмпирик томьёо	
А бодис	В бодис

Даалгавар 2. Гарган авсан **В** бодисыг натрийн гидросульфитийн уусмалд бүрэн уусган 10 °C хүртэл хөргөсний дараа 46 г калийн цианидыг бага багаар нэмэн урвалыг 1 цагийн турш явуулав. Урвалын холимогт эфир нэмж хандлан илүүдэл цианидыг урвалын орчноос салгасны дараа 200 мл концентрацитай давсны хүчил нэмж 10–15 °C-д шөнийн турш байлгаад урвалын холимогт хангалттай хэмжээний ус нэмж халаан эфирийг бүрэн ууршуулав. Урвалын холимгийг 100 °C-д 3 цагийн турш гидролизод оруулсны дараа 30%-

ийн натрийн гидроксидын уусмалаар саармагжуулж эфирээр хандлахад $C_6H_{10}O_3$ томьёотой 52 г цагираг бүтэцтэй, рацемат **E** бодис үүсэв. **C**, **D** бодисуудын бүтцийг зурна уу. **E** бодис болон түүний энантиомер **E′** бодисын орон зайн бүтцийг тус тус дүрслэн зурна уу. **(2 оноо)**


C бодис	D бодис
E бодис	E′ бодис

Даалгавар 3. Гарган авсан **E** бодисын рацемат холимгоос 4,16 г авч шинэхэн нэрсэн 8 г β-аланины этилийн эфиртэй 70 °C-д гурван цагийн турш урвалд оруулахад **F** бодис үүсдэг ба урвалын холимог дээр натрийн гидроксидын уусмал нэмж гидролизын урвал явуулснаар 6,14 г витамин B5-ын рацемат холимог гарган авдаг. **F** бодисын бүтцийг зурна уу. **(1 оноо)**

F бодис

Даалгавар 4. Нийт урвалын гарцыг тооцоолж аравны нарийвчлалтай хувиар илэрхийлнэ үү. **(1,5 оноо)**

Гарц, %



Бодлого 3. Азот ба түүний нэгдлүүд (Tier −5)


Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 4-р бодлого)

Энэ бодлого азот болон түүний зарим нэгдлийн тухай. Химийн шинж чанар, молекулын бүтэц, мөн термодинамик ба кинетикийн асуудлуудыг тайлбарлана.

A. Азотын молекул — харьцуулалт

Молекул хүчилтөрөгчөөс ялгаатай нь молекул азот нэлээд идэвхгүй. Харгалзах МО схемүүдийг харьцуулах замаар энэ идэвхгүй байдлыг тайлбарлаж болно. Доорх зурагт N_2, O_2 болон азотын хамгийн чухал нэгдлүүдийн нэг болох NH_3-ын МО схемийг үзүүлэв.

3.1. Схем бүрийн доорх нүднүүдэд зөв элементийн тэмдэг болон молекулын томьёог бичиж, схемүүдийг тэмдэглэ. Схемүүдийг электроноор (сумаар) дүүргэ.



3.2. Соронзон шинж болон холбооны эрэмбийг заа:

Азот N_2	**Хүчилтөрөгч O_2**
Холбооны эрэмбэ: _____	Холбооны эрэмбэ: _____
☐ диамагнит	☐ диамагнит
☐ парамагнит	☐ парамагнит

B. Аммиак

Жил бүр 180 сая орчим метрийн тонн аммиак үйлдвэрлэдэг нь түүнийг хамгийн чухал бараа химийн бодисуудын нэг болгодог. Бараг бүх аммиакийг дараах урвалд үндэслэсэн Хабер–Бошийн процессоор нийлэгжүүлдэг:

$$N_2(x) + 3H_2(x) \rightarrow 2NH_3(x) \qquad \text{(R 3.1)}$$

Дараах тооцоонд шаардлагатай 298 K дахь зарим термодинамик өгөгдөл:

	$\Delta_f H°$ / кЖ·моль$^{-1}$	$S°$ / Ж·моль$^{-1}$·К$^{-1}$	$C_p°$ / Ж·моль$^{-1}$·К$^{-1}$
N_2(x)	0	191,6	29,1
H_2(x)	0	130,7	28,8
NH_3(x)	−45,9	192,8	

3.3. Дэлхий даяар аммиак үйлдвэрлэх явцад 298 K-д изобар нөхцөлд ялгарах дулааны нийт хэмжээ Q_1-ийг Жоулиар тооцоол.

2076 онд гарах «Оддын дайн: XIX анги — Химийн хүч» киноонд шинэ «Үхлийн од» гарна гэсэн цуу яриа байна. Энэхүү аварга зэвсэг дээр дурдсан 180 сая метрийн тонн аммиакийг аварга бомбон калориметрт үйлдвэрлэж, хожим нь тогтоосон гаригийг устгахад ашиглах аж.

3.4. Бомбон калориметрт 298 K-д нэг удаагийн аммиак үйлдвэрлэхэд ялгарах дулааны нийт хэмжээ Q_2-ийг тооцоол.

3.5. Нэг удаагийн аммиак үйлдвэрлэхийн тулд «Үхлийн од»-нд хадгалах шаардлагатай урвалжуудын нийт массыг тооцоол.

Одоо зохиомол бус шинжлэх ухаан руугаа буцъя. Химийн тэнцвэрийг танилцуулахдаа Хабер–Бошийн процессыг ихэвчлэн авч үздэг.

3.6. 298 К-д (R 3.1) тэгшитгэлийн дагуу аммиак үүсэх урвалын K_p-г тооцоол.

Урвалын хурдыг нэмэгдүүлэхийн тулд аммиакийн нийлэгжлийг ихэвчлэн 400 °C-д явуулдаг.

3.7. $\Delta_R H$ ба $\Delta_R S$ нь 298 К дахь утгатайгаа ижил гэж үзээд 400 °C-д аммиак үүсэх урвалын K_p-г тооцоол.


Бодит байдал дээр урвалын энтальпи мэдээж температураас хамаардаг. (R 3.1) урвалын тэнцвэрийн тогтмолын дараах утгууд мэдэгдэж байна:

T	$\boldsymbol{K_p}$
500 К	$1{,}14\cdot10^{-1}$
600 К	$2{,}11\cdot10^{-3}$
700 К	$1{,}12\cdot10^{-4}$

3.8. Эдгээр утгад үндэслэн $\Delta_R H_{650}$-г аль болох нарийвчлалтай тооцоол.

Бодлого 4. Оросын анхны үеийн органик химичид ба Марковниковын дүрэм (Tier 5)

Эх сурвалж: ОУХО-ийн бэлтгэл бодлого, 2020, Турк (Бодлого 4)




Өнгөрсөн жил Марковниковын дүрэм нээгдсэний 150 жилийн ойг тэмдэглэсэн бөгөөд энэ дүрмийг Владимир В. Марковников 1869 онд томьёолжээ. Марковников бол Оросын эртний нэрт эрдэмтэн Александр Бутлеровын докторант байв. Тэрээр 1869 онд хамгаалсан докторын диссертацдаа органик химийн бараг бүх сурах бичигт байдаг алдарт дүрмээ нээсэн юм. Марковниковын дүрмээр бол тэгш хэмт бус алкен эсвэл алкин галогент устөрөгчтэй (хлорт устөрөгч, бромт устөрөгч, иодот устөрөгч) урвалд ороход НХ-ийн устөрөгчийн атом нь устөрөгчийн атомын тоо хамгийн олон байгаа нүүрстөрөгчийн атомд нэгддэг. Гэвч урвалж эсвэл субстратаас хамаарч зарим тохиолдолд эсрэг үр дүн гарах боломжтой бөгөөд ийм урвалыг *анти*-Марковниковын нэгдэх урвал гэнэ. Марковниковын дүрэм нь алкен, алкинд галогент устөрөгч нэгдэх урвалд зориулан боловсруулагдсан, чухам тэр урвалд хэрэглэгддэг боловч бусад олон нэгдэх урвалыг ч региосонгомол чанараас нь хамааруулан Марковниковын эсвэл *анти*-Марковниковын нэгдэх урвал гэж тодорхойлдог.


Үнэн хэрэгтээ уг дүрмийг дараах байдлаар шинэчлэн томьёолох нь зүйтэй: «*ийм төрлийн хос эсвэл гурвалсан холбоонд нэгдэх урвал нь илүү тогтвортой завсрын бүтээгдэхүүнээр дамжин явагддаг*». Зарим тохиолдолд электроны нөлөөнөөс гадна орон зайн (стерик) нөлөө ч Марковниковын болон *анти*-Марковниковын нэгдэх бүтээгдэхүүн үүсэхэд нөлөөлж болно.

Дараах даалгаврууд нь голчлон нэрт органик химич Александр Бутлеровын шавь болон Казаны их сургуулийн (ОХУ, Татарстан) хамтран зүтгэгчдийнх нь тодорхойлсон нээлтүүдтэй холбоотой.

4.1. **A**–**E** гол бүтээгдэхүүний бүтцийн томьёог стереохимийг нь харгалзан **<u>зүр</u>** (оптик изомерыг тооцохгүй).




4.2. Дараах урвалуудын **F** ба **G** гол бүтээгдэхүүний бүтцийн томьёог **<u>зүр</u>**.



Вагнер–Меервейны дахин бүлэглэл (WMR)


Вагнер бол Бутлеров, Марковников нартай нэгэн үед Казаны их сургуульд ажиллаж байсан бас нэг нэрт эрдэмтэн юм. Вагнер борнилхлорид дотоод дахин бүлэглэлд орж пинен үүсгэдэг гэж үзсэн. Хожим Меервейн энэ төрлийн дахин бүлэглэлийг ерөнхийлөн тайлбарласан. Иймээс ийм төрлийн урвалыг Вагнер–Меервейны дахин бүлэглэл гэж нэрлэх болжээ. Эдгээр урвал нь карбокатион үүсэх үед явагддаг. Ерөнхийдөө карбокатион нь боломжтой бол хөрш бүлгийн шилжилтээр илүү тогтвортой карбокатион болж дахин бүлэглэгддэг. Түүнчлэн урвал карбокатион эсвэл карбокатион төст завсрын бүтээгдэхүүнээр дамжихгүй бол дахин бүлэглэл явагдахгүй.

4.3. Урвал бүрд үүсэх завсрын бүтээгдэхүүнийг харгалзан **H** ба **I** урвалж, **J**–**M** гол бүтээгдэхүүний бүтцийн томьёог **зур**.



Хүчлээр катализлагдах Вагнер–Меервейны дахин бүлэглэл

4,4-диметилциклогекса-2,5-диен-1-оныг хүчлийн катализатортай урвалд оруулахад нэгэн нэгдэл үүссэн бөгөөд түүний ЦСР-ийн өгөгдлийг доор өгөв.



N нэгдлийн хувьд: ^{1}H ЦСР (300 МГц, $CDCl_3$): δ = 6,95 (d, *J* = 8,0 Гц, 1H); 6,61 (d, *J* = 2,8 Гц, 1H); 6,57 (dd, *J* = 8,0; 2,8 Гц, 1H); 5,39 (bs, 1H); 2,16 (s, 3H); 2,14 (s, 3H). ^{13}C ЦСР (100 МГц, $CDCl_3$): δ 153,4; 137,9; 130,4; 128,6; 116,6; 112,3; 19,8; 18,7.

4.4. N бүтээгдэхүүний бүтцийг **ол**, урвалын боломжит механизмыг **санал болго**.


4.5. ЦСР-ийн ампул дахь уусмалд нэг дусал D_2O нэмсний дараа ^{1}H ЦСР спектрт ямар өөрчлөлт гарах вэ?

Зайцевын дүрэм

Өөрийн нэрээр нэрлэгдсэн дүрмийг (Зайцевын дүрэм; латинаар Zaitsev, Saytzeff эсвэл Saytzev гэж бичдэг) томьёолсон Зайцев бол Бутлеровын бас нэг докторант байв. Зайцевын дүрэм нь салгах (элиминацийн) урвалаар давамгайлан үүсэх алкен бүтээгдэхүүнийг урьдчилан тодорхойлох эмпирик дүрэм юм. Химич Александр Зайцев Казаны их сургуульд

салгах янз бүрийн урвалыг судалж, үүссэн алкенуудад нийтлэг зүй тогтол байгааг ажигласан. Ерөнхийд нь хэлбэл, Зайцевын дүрмээр салгах урвалд хамгийн их халагдсан бүтээгдэхүүн давамгайлан үүсдэг. Дараах даалгавар нь голчлон Зайцевын дүрэмтэй холбоотой.

4.6. Салгах урвалын **O**–**Q** бүтээгдэхүүн болон **R** нэгдлийн бүтцийн томьёог **зур**. Доорх схемд үзүүлсэн **R**-ийн дулааны урвалаар үүсэх гол бүтээгдэхүүн юу вэ?



4.7. EtONa-тай харьцуулахад **Q**-ийн эзлэх хувийг нэмэгдүүлэхийн тулд **аль суурийг (суурьтуудыг) хэрэглэж болох** вэ?

- ☐ NaOMe
- ☐ KOMe
- ☐ *i*-PrOK
- ☐ *t*-BuOK
- ☐ NH_3
- ☐ DBU
- ☐ *i*-Pr_2NEt

Бодлого 5. Азотын (I) ислийн хими (Tier 5)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 2-р бодлого)



Азотын (I) исэл N_2O-г хөөсөрсөн цөцгий шахах хий, автомашины хөдөлгүүрт шаталтыг сайжруулах түлшний нэмэлт, мөн анагаах ухаан, шүдний эмчилгээнд мэдээ алдуулагч болгон хэрэглэдэг. Амьсгалахад азотын (I) исэл хэт хөөрөл үүсгэж болдог тул «инээдийн хий» гэсэн хоч авсан. Азотын (I) ислийг зугаа цэнгэлийн зорилгоор хэрэглэх нь эрүүл мэндэд ноцтой эрсдэлтэй болохыг одоо мэддэг болсон.

Азотын (I) ислийг будаг үйлдвэрлэлд хэрэглэдэг сул хүчил болох азотлогийн хүчил HNO_2-оос гарган авч болно.

(a) HNO_2-ийн цэг-загалмай диаграмыг (dot and cross) зур.

Азотлогийн хүчлийг хоёр өөр аргаар азотын (I) исэл болгон хувиргаж болно. Эхний аргыг доор үзүүлэв. Эхлээд азотлогийн хүчил O_2-тэй урвалд орж **A** молекул үүсгэнэ. Дараа нь **A** молекул аммиактай урвалд орж $[\mathbf{B}^+][\mathbf{C}^-]$ давс үүсгэх бөгөөд энэ давс халаахад задарч азотын (I) исэл ба ус үүсгэнэ.

$$HNO_2 \xrightarrow{O_2} \mathbf{A} \xrightarrow{NH_3} [\mathbf{B}^+][\mathbf{C}^-] \xrightarrow{\text{халаах}} N_2O + 2H_2O$$

Элементийн шинжилгээгээр **A** массын хувиар 1,60% устөрөгч, 22,23% азот агуулдаг.

(b) **A**-гийн томьёог тодорхойл.

(c) $\mathbf{B}^+$ ба $\mathbf{C}^-$ ионуудыг хэлбэрийг нь тодорхой харуулж зур.

Хоёр дахь аргаар азотлогийн хүчлийг халааж задалдаг. Азотлогийн хүчлийн хоёр молекул тутамд **D**, **E**, ус тус бүрийн нэг молекул үүснэ. **E** нь өнгөгүй **X** хийтэй тэнцвэрт байдаг улаан хүрэн өнгийн хий юм.

Дараа нь **D** ба **E** хоорондоо урвалд орж **F** молекулыг үүсгэх бөгөөд **F** халаахад задарч азотын (I) исэл ба хүчилтөрөгч үүсгэнэ.

(d) **D**, **E**, **F**, **X**-ийн томьёог бич.


Азотын (I) исэл нь голдоо азотын атомтай шугаман молекул юм.

(e) N_2O-ийн бүтцийг зур.

Бодлого 6. E10 бензин (Tier 5)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт Q1)

Уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаантай тэмцэхэд туслах зорилгоор 2021 оны 9-р сард Их Британийн засгийн газар шатахуун түгээх станцуудын стандарт бензиний зэрэглэлийг E5-аас E10 болгон өөрчилсөн. Эдгээр E утга нь этанол–нүүрсустөрөгчийн түлшний холимог дахь этанолын хувийг заадаг. E5-аас E10 руу шилжсэн нь 2021 оны 10-р сард гарсан бензиний хомсдолд нөлөөлсөн хүчин зүйлсийн нэг болсон гэж үздэг, учир нь борлуулагчид E5-ын нөөцөө дуусгахыг оролдсон.



E утга болон октаны тоог хоёуланг нь шатахуун түгээх станц дээр харуулдаг. Октаны шулуун гинжит изомер хөдөлгүүрт «тогших» хандлагатай тул бензинд бага хэмжээгээр л агуулагддаг. Тогшилт гэдэг нь түлш хугацаанаасаа өмнө асах үзэгдэл бөгөөд энэ нь хөдөлгүүрийн үр ашгийг бууруулдаг. Октаны салаалсан гинжит изомерууд хамаагүй бага тогшдог бөгөөд бензинд эдгээр нь их хэмжээгээр агуулагддаг. Гол изомеруудын нэг нь 2,2,4-триметилпентан юм.

(a) 2,2,4-триметилпентаны араг ясан томьёог зур.

Түлшний холимогт E5, E10-ын адил этанол холих нь мөн тогшилтыг бууруулдаг. Этанол бол биотүлш бөгөөд ихэвчлэн тариалангийн ургамлын сахарыг исгэж гаргадаг. Ургамал агаар мандлаас нүүрсхүчлийн хий шингээж, фотосинтезээр глюкоз ($C_6H_{12}O_6$) зэрэг сахар болгон хувиргадаг.

(b) Фотосинтезийн явцад нүүрсхүчлийн хийнээс глюкоз үүсэх урвалын тэгшитгэлийг бич.

Глюкозын агааргүй исгэлтээр этанол ба нүүрсхүчлийн хий үүсдэг.

(c) Глюкозын агааргүй исгэлтийн урвалын тэгшитгэлийг бич.

Үр ашигтай түлшний шинж чанаруудын нэг нь түүний ялгаруулах энергийн хэмжээ буюу шаталтын энтальпи юм. Үүнийг тодорхойлох нэг арга бол холбооны дундаж энтальпийг ашиглах явдал. Зарим холбооны дундаж энтальпийг доор өгөв.

Холбоо	**Холбооны дундаж энтальпи / кЖ моль$^{-1}$**
C–C	347
C–H	413
O=O	498
C–O	358
C=O	805
O–H	464

Энэ аргаар тооцоолоход октаны бүх изомерын хувьд ижил утга гарна.

(d) Октаны нэг изомерын шаталтын энтальпийг тооцоол.

1 литр E10 түлш 100 мл этанол ба 900 мл октаны изомерууд, харин 1 литр E5 түлш 50 мл этанол ба 950 мл октаны изомерууд агуулна гэж үз. Цэвэр этанолын нягт 0,789 г·см$^{-3}$, цэвэр октаны изомеруудын нягт 0,703 г·см$^{-3}$. Холиход эзэлхүүн өөрчлөгдөхгүй гэж үзэж болно.

Холбооны дундаж энтальпиар тооцоолсон этанолын шаталтын энтальпи −1276 кЖ моль$^{-1}$.

(e) E5 ба E10 түлш тус бүрийн хувьд 1 литр түлш шатахад ялгарах энергийг кЖ-оор тооцоол.

Хэрэв (d) хэсгийн хариуг олоогүй бол энэ тооцоонд октаны изомеруудын шаталтын энтальпийг −6666 кЖ моль$^{-1}$ гэж авч болно.

(f) 1 литр E5 шатахад ялгарах энергийг 100% гэж аваад 1 литр E10 түлш шатахад ялгарах энергийн хувийг тооцоол.


Этанолын шаталтаар ялгарсан бүх нүүрсхүчлийн хий нь ургамал ургах үед шингээсэн нүүрсхүчлийн хийгээр нөхөгддөг. Иймээс E5 ба E10 түлшний CO_2 ул мөрийг харьцуулахдаа этанолын хувь нэмрийг тооцдоггүй.

(g) 1 литр E5 түлш шатахад үүсэх CO_2-ыг 100% гэж аваад 1 литр E10 түлш шатахад үүсэх CO_2-ын хувийг тооцоол. Зөвхөн октаны изомерууд шатахад үүсэх CO_2-ыг тооцно уу.

Бодлого 7. Ханиад намдаах эм (Tier 5)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 4-р бодлого)

2017 оны 9-р сард Их Британийн Ерөнхий сайд Тереза Мэй Консерватив намын их хурал дээр үг хэлэх үеэрээ хүчтэй ханиалгасан. Benylin® зэрэг ханиадны эмэнд агуулагддаг ханиад намдаах эм декстрометорфан түүнд тус болж болох байсан. Энэ бодлого декстрометорфаны нийлэгжлийн тухай. Нийлэгжилд зарим бат бөх холбоо болон зарим тогтвортой карбокатион үүсдэг.



декстрометорфан




Декстрометорфаныг ихэвчлэн гидробромидын моногидрат давс хэлбэрээр хэрэглэдэг.

(a) Давсанд протонжсон декстрометорфаны атомыг хариултын хуудсанд дугуйлж тэмдэглэ.

(b) Декстрометорфаны молекулын томьёог тодорхойлж, улмаар декстрометорфаны гидробромидын моногидрат давсны молийн массыг тооцоол.

Декстрометорфаны нийлэгжил хэд хэдэн үе шаттай. Нийлэгжлийг дүрсэлсэн схемүүдэд урвалын дайвар бүтээгдэхүүнийг үргэлж харуулаагүй болохыг анхаарна уу.

Декстрометорфаны нийлэгжил **F** нэгдлийг нийлэгжүүлэхээс эхэлдэг.



(c) A, **B**, **C**, **D**, **E** нэгдлүүд болон **X** хийн бүтцийг зур.

Бодлого 8. Метанолын термодинамик (Tier +5)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 3-р бодлого) · нийт 6 оноо

Хүснэгтэд өгөгдсөн үр дүнг ашиглан дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

	H_2(х)	**O_2(х)**	**CO(х)**	**CO_2(х)**	**H_2O(ш)**	**H_2O(х)**	**CH_3OH(ш)**	**CH_3OH(х)**
$-\Delta_{үүс}H°_m$, кЖ·моль$^{-1}$	0	0	110,52	393,51	285,83	241,82	238,66	200,66
$S°_m$, Ж·К$^{-1}$·моль$^{-1}$	130,68	205,14	197,67	213,74	69,91	188,83	126,80	239,81

(х) — хий, (ш) — шингэн

Даалгавар 1. 400 К температур, 100 кПа даралтын нөхцөлд метанолын крекинг задралаар устөрөгч үүсэх урвалын тэнцвэрийн тогтмолыг тооцоолно уу. Температурын хамаарлыг тооцохгүй болно. **(3 оноо)**

Даалгавар 2. 0,426 г метанолыг 1 л эзэлхүүнтэй хатуу саванд хийж температурыг 298 К-д тогтмол хадгалахад хий болон шингэн фаз дахь метанолын массын харьцаа хэд байх вэ? Метанолын буцлах температур 337,7 К. **(3 оноо)**

Бодлого 9. Çay, Cha, Chai, Te, Tea, Tee, Thé, Thee ба Эрл Грей цайны амт: Бергамот (Tier −4)

Эх сурвалж: ОУХО-ийн бэлтгэл бодлого, 2020, Турк (Бодлого 3)


Үг	Хэл
Cha	Хятад, Япон, Солонгос, Португал…
Chai	Орос, Перс…
Çay	Турк, Азербайжан…
čaj	Босни, Хорват, Чех, Серб, Словак…
Shay	Араб…
Te	Итали, Испани…
Tea	Англи…
Tee	Герман…
Thé	Франц…
Thee	Голланд…
Chaay	Хинди…

Цай (туркээр: *çay*) нь Турк улс даяар болон гадаадад амьдардаг туркуудын дунд түгээмэл ундаа юм. Туркийн цайны соёл Азербайжанаас Балканы хойгийн зарим улс хүртэл тархсан байдаг. Турк улс нэг хүнд ногдох цайны хэрэглээгээр дэлхийд тэргүүлдэг (жилд нэг хүнд 2,5 кг) бөгөөд удаах байрт Их Британи (жилд нэг хүнд 2,1 кг) ордог.





Бергамотен ба түүний уламжлалууд (**1**–**4**) нь сесквитерпенүүд бөгөөд пинаны монотерпенүүдийн аналог юм. Бергамотын тосонд агуулагддаг бергамотенүүд нь Эрл Грей цайны үнэр, амтыг бүрдүүлэхэд оролцдог.



1 α-*транс*-бергамотен


2 α-*цис*-бергамотен

3 β-*транс*-бергамотен

4 β-*цис*-бергамотен

9.1. Дараах урвалын схемд α-*транс*-бергамотен (**1**)-ийг нийлэгжүүлэх аргыг үзүүлэв. **A**–**G** бүтээгдэхүүний бүтцийн томьёог **зур**.

9.2. A-г **B** болгон хувиргахад Me_3NO урвалж ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?




Бодлого 10. Органик нийлэгжил: коницеины нийлэгжил (Tier −4)

Эх сурвалж: Австрийн химийн 46-р олимпиад, нөөц тэмцээн II, 5-р бодлого (M. Scherl) · нийт 19 оноо, А хэсэг 15 оноо

(Jung, M.E.; Choi, Y.M. J. Org. Chem. 1991, 56, 6729.)

Энэ бодлого гетероцикл алкалоид болох коницеины нийлэгжлийн тухай. 1991 онд үүнийг перициклийн урвалын гоёмсог үе шатуудыг ашиглан нийлэгжүүлжээ.



10.1. **A**, **B**, **C**, **D**, **E**, **F**, **G** бодисуудын бүтцийн томьёог зур.

10.2. **D**-гийн бүтцийн томьёонд **E** үүсэхийг үндэслэлтэй харуулах «сумнуудыг» зур.

10.3. **E**-гийн бүтцийн томьёонд **E** урвалжаас (өгөгдсөн) **F** үүсэхийг үндэслэлтэй харуулах «сумнуудыг» зур. Өгөгдсөн урвалын төрлийг аль болох нарийвчлан нэрлэ. Энэ урвалыг юу гэж нэрлэдэг вэ?

10.4. **C** ⟶ **D** урвалд KO^tBu ямар үүрэг гүйцэтгэдгийг бич. Энэ урвал ямар механизмаар явагддагийг нэрлэ.

10.5. **A**-гийн бүтцэд мезил бүлгийг оруулсан шалтгааныг заа. Энэ талаар хамгийн ихдээ нэг өгүүлбэр бич!

Бодлого 11. Хабер–Бошийн процесс (Tier 4)

Тайлбар: Шаардлагатай термодинамик өгөгдлийг бодлогын төгсгөлд өгөв.

Хабер–Бошийн процесст аммиакийг (NH_3) төмөрт суурилсан катализатор ашиглан харгалзах энгийн бодисуудаас нь шууд нийлэгжүүлдэг.

1. Аммиак нийлэгжих урвалын тэгшитгэлийг бич.

2. $\Delta_r H^\circ$ ба $\Delta_r S^\circ$ нь температураас хамаарахгүй гэж үзээд аммиак нийлэгжих урвалын $K_p = 1$ байх температур T (K)-ийг тодорхойл.

Бодит байдалд $\Delta_r H^\circ$ ба $\Delta_r S^\circ$ нь температураас хамаардаг.

3. Хийнүүдийн дулаан багтаамж тогтмол, харин энтальпи ба энтропи нь температураас хамаарна гэж үзээд 300 °C дахь K_p-ийн утгыг тооцоол.

Термодинамик өгөгдөл ($T = 298$ K, $p = 1$ бар):

Бодис	$\Delta_f H^\circ$ / кЖ·моль$^{-1}$	S° / Ж·моль$^{-1}$·К$^{-1}$	C_p / Ж·моль$^{-1}$·К$^{-1}$
H_2(хий)	0	130,7	28,8
N_2(хий)	0	191,6	29,1
NH_3(хий)	−46,2	192,7	35,1


Бодлого 12. Том тоннажийн нүүрсустөрөгчөөс эм хүртэл (Tier 4)

Эх сурвалж: Оросын олимпиадын бодлого (Задача 10-4)

Том тоннажийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болох C_xH_y нүүрсустөрөгчийн уурыг (300 °C, 1 атм-д 1,175 л) стехиометрийн хэмжээний хүчилтөрөгчтэй хольж, гарсан холимгийг битүү саванд шатаав. Усны уурыг (1,8 г) бүрэн конденсацлуулсны дараа даралт анхны холимгийн даралттай харьцуулахад 1,375 дахин багассан.

12.1. C_xH_y-ийн молекулын томьёог тооцоолж, бүтцийн томьёог бич.

C_xH_y нь түгээмэл хэрэглэгддэг **X** эмийг үйлдвэрлэлд нийлэгжүүлэх доорх схемийн эхлэл нэгдэл юм.



12.2. **A**–**K** болон **X** нэгдлүүдийн бүтцийн томьёог бич. Элементийн шинжилгээгээр **G** бодис массын хувиар 16,37% хлор агуулдаг, харин **C** энэ элементийг агуулдаггүй; мөн **J** бодис массын хувиар 11,02% азот агуулдаг болохыг анхаар.





12.3. $y/x = m/n$ гэдэг нь мэдэгдэж байгаа бол C_nH_m найрлагатай өөр нэгэн том тоннажийн бүтээгдэхүүнээс **D**-г нийлэгжүүлэх аргыг санал болго.

Бодлого 13. Альдогексозын бүтэц тогтоох (Tier 4)





Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 4-р бодлого) · нийт 6 оноо

Нэгэн альдогексоз **A**-г метанол дахь $NaBH_4$ ашиглан ангижруулахад оптик идэвхтэй **B** үүсдэг. **A**-г Вуул (Wohl)-ын задралд оруулахад (энэхүү задралд моносахарид гидроксиламинтай нуклеофиль нэгдэх урвалд орж оксим үүсгэх ба түүнийг цааш цууны ангидрид ба натрийн ацетатын холимгоор үйлчлэхэд цианогидрин үүсдэг; үүссэн цианогидрин суурилаг орчинд цианы хүчлийг ялгаруулан нэгээр цөөн тооны C атом бүхий альдегид болдог) **C** альдопентоз үүсэх ба түүнийг ангижруулахад оптик идэвхгүй **D** альдитол үүсдэг. Мөн **C** нь Вуулын задралаар альдотетроз **E**-г үүсгэх ба түүнийг исэлдүүлэхэд оптик идэвхтэй **F** альдарын хүчил үүсдэг. **A** альдогексозын хоёр төгсгөлийг солиход өөр альдогексоз **G** болно. Дараах хүснэгтэн мэдээллийг ашиглан даалгаврыг гүйцэтгэнэ үү.





Даалгавар 1. A нэгдэлд тохирох хариулт (a)-ыг сонгоно уу. **(0,5 оноо)**

A	1		2		3		4	





Даалгавар 2. B нэгдэлд тохирох хариулт (b)-ыг сонгоно уу. **(0,5 оноо)**

B	5		6		7		8	





Даалгавар 3. C нэгдэлд тохирох хариулт (cd)-ыг сонгоно уу. **(1 оноо)**

C	09		10		11		12	





Даалгавар 4. D нэгдэлд тохирох хариулт (ef)-ыг сонгоно уу. **(1 оноо)**

D	13		14		15		16	





Даалгавар 5. E нэгдэлд тохирох хариулт (gh)-ыг сонгоно уу. **(1 оноо)**

E	17		18		19		20	

Даалгавар 6. F нэгдэлд тохирох хариулт (ij)-ыг сонгоно уу. **(1 оноо)**

F	21		22		23		24	

Даалгавар 7. G нэгдэлд тохирох хариулт (kl)-ыг сонгоно уу. **(1 оноо)**

G	25		26		27		28	

Бодлого 14. Олон талт нил ягаан (Tier +4)

Эх сурвалж: Балтийн орнуудын химийн 14-р олимпиад (BChO), 2006, Рига, Латви (1-р бодлого)

A элементийг Чилийн селитртэй хольцоор байгальд тохиолддог **B** нэгдлээс нь ялгаж авч болно. Эхлээд **B** нэгдлийг NaSH-ийн усан уусмалаар боловсруулна. Дараа нь энгийн бодис **A**-г усан уусмалаас ксилолоор экстракцлахад ксилол нил ягаан өнгөтэй болдог. **A** элемент цардуулын уусмалтай мөн хөх өнгийн нэгдэл үүсгэдэг.

a) **A** ба **B**-г тодорхойл.

b) Чилийн селитрийн химийн томьёог бич.

c) **B**-г NaSH-ийн усан уусмалаар боловсруулах урвалын тэгшитгэлийг бич.

A элемент анагаах ухаанд өргөн хэрэглэгддэг. 1986 онд Чернобылийн атомын цахилгаан станцын ослын дараа Припять хотын ойролцоо амьдардаг хүмүүст **A** агуулсан эм өгсөн.

d) Цацраг идэвхт хур тунадас унах үед **A** элемент агуулсан эм уух шаардлагатайн учрыг тайлбарла.

A элемент цахилгаан техникт ч хэрэглэгддэг. Олон тээврийн хэрэгслийн зарим цахилгаан эд ангид бага хэмжээний **A** болон түүний вольфрамын давс агуулагддаг.

e) Цахилгаан эд анги ажиллах явцад түүнд явагдах буцах урвалын тэгшитгэлийг бич.

A элементийг чийглэг улаан фосфортой урвалд оруулахад өнгөгүй, хортой **C** хий ялгардаг. Хийн төлөвт **C** нэгдэл нь усан орчинд бүрэн протолизд ордог (ионуудад задардаг) хүчтэй хүчил юм.

f) **A** элемент ба чийглэг улаан фосфорын хоорондох урвалын тэгшитгэлийг бич.

g) 12,79 г **C**-г 1,00 дм^3 усанд уусгав. **C** нэгдлийн усан уусмалын pH-ийн утгыг тооцоол.

h) **g)**-д дурдсан уусмалаас 1,00 см^3-ийг 10,0 м^3 цэвэр нэрмэл усаар шингэлэв. Шинээр гарсан уусмалын pH-ийн утгыг тооцоол.

Бодлого 15. Хүчил–суурийн тэнцвэр (Tier +4)

Эх сурвалж: Польшийн химийн олимпиад (Zadanie 1)

Лабораторид хоёр хүчлийн уусмалыг хооронд нь холив: $c_1 = 10^{-2}$ моль·дм$^{-3}$ концентрацтай, $pH_1 = 3{,}38$ бүхий цууны хүчлийн $V_1 = 50$ мл уусмал ба $c_2 = 10^{-2}$ моль·дм$^{-3}$ концентрацтай, $pH_2 = 2{,}95$ бүхий сүүний хүчлийн ($CH_3CH(OH)COOH$) $V_2 = 100$ мл уусмал.

Даалгавар:

a. *(2 оноо)* Эдгээр сул хүчлийн pK_{a1} ба pK_{a2}-ийн утгыг тооцоол.

b. *(6 оноо)* Хоёр сул хүчлийн уусмалын холимог дахь H^+ ионы концентрацийн ($[H^+]$) ерөнхий томьёог анхны уусмалуудын концентраци c_1, c_2, анхны уусмалуудын эзэлхүүн V_1, V_2, хүчлийн диссоциацийн тогтмол K_{a1}, K_{a2} болон усны ионы үржвэр K_w-ийн функц хэлбэрээр гарга.

c. *(7 оноо)* Гарган авсан томьёог ерөнхий тохиолдолд хэрэглэж болох, илүү энгийн илэрхийлэлд (хоёрдугаар зэргийн олон гишүүнтэд) хүргэх дор хаяж хоёр үндэслэлтэй хялбарчлалыг санал болго. Эдгээр хялбарчлалыг хэрэглэх ерөнхий нөхцөлийг заа. Энэ тодорхой тохиолдолд эдгээр хялбарчлалыг хэрэглэж болох уу? Хариултаа тооцоогоор үндэслэ.

d. *(1 оноо)* Гарсан уусмалын pH-ийг тооцоол.

Мөн хоёр хүчлийн уусмалын хоёр дахь холимгийг бэлтгэв: эхний уусмалыг өөрчлөөгүй, харин хоёр дахь уусмал нь сүүний хүчилтэй ижил эзэлхүүн, концентрацтай давсны хүчлийн уусмал байв ($V_2 = 100$ мл, $c_2 = 10^{-2}$ моль·дм$^{-3}$).

Даалгавар:

e. *(4 оноо)* Энэ тодорхой холимгийн хувьд хэрэглэж болох бүх үндэслэлтэй хялбарчлалыг ашиглан H^+ ионы концентрацийн ($[H^+]$) томьёог анхны уусмалуудын концентраци c_1, c_2, анхны уусмалуудын эзэлхүүн V_1, V_2 болон хүчлийн диссоциацийн тогтмол K_{a1}-ийн функц хэлбэрээр гарга.


f. *(1 оноо)* Гарсан уусмалын pH-ийг тооцоол.

Тооцоололд хүчлийн уусмалуудыг холиход уусмалын нийт эзэлхүүн өөрчлөгдөхгүй гэж үз.

Бодлого 16. Твистан молекул (Tier +4)

Эх сурвалж: тодорхойгүй (эх бичвэрт 4-р бодлого)


Циклогексаны (C_6H_{12}) араг ясан бүтцийг ихэвчлэн зөв зургаан өнцөгтөөр дүрсэлдэг ч бодит байдал дээр энэ нь *конформаци* гэж нэрлэгддэг олон янзын хэлбэрт оршин байдаг уян хатан молекул юм. Эдгээр конформациас хоёрыг нь — *сандал* ба *мушгирсан завь* хэлбэрийг доор үзүүлэв. Зургаан гишүүнт цагираг дахь нүүрстөрөгчийн атомуудыг холболтыг нь харуулахын тулд 1–6 гэж дугаарлав.



Сандал хэлбэр нь циклогексаны хамгийн бага энергитэй конформаци бөгөөд бүх холбооны өнцөг нь тетраэдр нүүрстөрөгчийн атомын идеал өнцөгтэй бараг тэнцүү байдаг. Мушгирсан завь хэлбэр илүү өндөр энергитэй.

(a) Циклогексаны сандал хэлбэр дэх идеал C–C–C өнцөг зөв зургаан өнцөгтийн өнцгөөс хэдэн градусаар ялгаатай вэ?


Адамантан молекулыг доор үзүүлсний дагуу циклогексаны сандал конформацад дахин дөрвөн нүүрстөрөгчийн атом нэмж төсөөлж болно. Ингэхэд өөр зургаан гишүүнт цагиргууд үүснэ. Адамантанд бүх зургаан гишүүнт цагираг сандал конформацдаа түгжигдсэн байдаг.



(b) Адамантан дахь давтагдахгүй зургаан гишүүнт цагираг бүрийн хувьд тухайн цагирагийн зургаан нүүрстөрөгчийн атомын дугаарыг холбогдсон дарааллаар нь, хамгийн бага дугаараас эхлэн бич (жишээ нь: -1-2-3-4-5-6-).

(c) Адамантаны ^{13}C ЦСР спектрт хэдэн дохио байх вэ (өөрөөр хэлбэл нүүрстөрөгчийн хэдэн өөр орчин байна вэ)?

